

“ХАРХОРИН” НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 04 дүгээр сарын 26 өдөр

Дугаар 01

Хархорин сум

*Компанийн 2024 оны үйл ажиллагаа болон
санхүүгийн тайлантай холбогдуулан
ТУЗ-аас гаргасан дүгнэлтүүдийг батлах тухай*

“Хархорин” Нээлттэй Хувьцаат Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9-г удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Компанийн 2024 оны жилийн үйл ажиллагааны талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг хангалттай хэмээн үзсүгэй.
2. Компанийн 2024 оны жилийн санхүүгийн тайлангийн тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг хангалттай хэмээн үзсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



П.УЧРАЛ

“ХАРХОРИН” НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 04 дүгээр сарын 26 өдөр

Дугаар 02

Хархорин сум

*Ногдол ашигтай холбогдуулан
ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг батлах тухай*

“Хархорин” Нээлттэй Хувьцаат Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 18-ний өдрийн 01/2025 тоот тогтоол, Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын шийдвэрийг тус тус үндэслэн, Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.6-г удирдлага болгон ТОГТООХ нь:

“Хархорин” Нээлттэй Хувьцаат Компани нь 2024 оны жилийн эцсийн аудитлагдсан санхүүгийн тайлангийн дагуу нийт 349,874.8 мянган төгрөгийн татварын дараах алдагдалтай ажилласантай холбогдуулан 2024 оны үйл ажиллагаанаас ногдол ашиг хуваарилахгүй тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 02 дугаар 18-ний өдрийн хурлаас гарсан шийдвэрийг зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



П.УЧРАЛ